МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Т.БАЯСГАЛАН

2026.04.24

# ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

## ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*/2025/*

| | |
|---|---|
| **ДНБ-ий өсөлт** 6.8 хувь | **Гадаад валютын нөөц** 7,005 сая $ |
| **Экспорт** 15.7 тэрбум $ | **Импорт** 11.3 тэрбум $ |
| **Үйл ажиллагаа явуулж буй ААНБ** 116.8 мянга | **Инфляц** 7.5 хувь |
| **ГШХО** 3.8 тэрбум $ | **Төсвийн тэнцэл** -1,232 тэрбум ₮ |

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

*/бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь/*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Бодит ДНБ 2025 онд **6.8 хувиар өслөө.**
- Эдийн засгийн өсөлтийг хөдөө аж ахуйн салбар болон уул уурхайн салбарын өсөлт голлон дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг саарууллаа.
- Боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж, тээврийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж өсөлтөд эергээр нөлөөллөө.

## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ДНБ

*/эзлэх хувиар/*




*Эх сурвалж: Сангийн яам*

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь 2025 онд **3 гаруй их наяд** төгрөгт хүрсэн.
- Энэ нь жил бүр өсөж буй боловч дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулбал **8 хувиас доош** байна.
- Өөрөөр хэлбэл төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлт, өсөн нэмэгдэж байгаа дэд бүтцийн хэрэгцээг хангахад хязгаарлагдмал юм.

# МОНГОЛ УЛСЫН 2026–2030 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

**188** төсөл
МОНГОЛ УЛСЫН 2026-2030 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

**88** төсөл — **1.** Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

Нийт төсөвт өртөг:

**70.1 их наяд ₮**

**2026-2030** онд санхүүжих дүн » **55.1 их наяд ₮**

**72** төсөл — **2.** Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Санхүүжилт шийдвэрлэх: » **65.4 их наяд ₮**

**29** төсөл — **3.** Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

*Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр*




- Улс, орон нутгийн төсөв — **39 төсөл**
- Гадаад зээл, тусламж — **25 төсөл**
- Шууд хөрөнгө оруулалт — **14 төсөл**
- **ТХХТ** — **4 төсөл**
- Засгийн газрын үнэт цаас — **2 төсөл**
- Холимог эх үүсвэр — **3 төсөл**
- Бусад эх үүсвэр — **1 төсөл**

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

ТХХТ нь төрийн хийх ёстой нийтийн зориулалттай **дэд бүтэц, төрийн үйлчилгээг хувийн хэвшилтэй түншлэн** үр ашигтайгаар төслүүдийг гүйцэтгүүлж, чанартай үйлчилгээг **олон нийтэд хүргэх** худалдан авах ажиллагааны нэг хэрэгсэл, тогтолцоо юм.

| | |
|---|---|
| ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ | ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛБӨР БОЛОН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛДЭГ |
| УРТ ХУГАЦААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ /20-30 ЖИЛ/ | ЭРСДЭЛИЙН ОНОВЧТОЙ ХУВААРИЛАЛТ |

## ТХХТ хууль эрхзүйн орчин /Улсаар/




*World Bank Benchmarking Infrastructure Development 2020*

## 2024 онд нийт

**315** төсөл

**100.7** тэрбум доллар

*World Bank Private Participation in Infrastructure (PPI)*

# ТҮНШЛЭЛИЙН ЗАРЧМУУД

| Олон нийтийн ашиг сонирхол | Чанар, хүртээмжийг сайжруулах | Сайн засаглал, эрсдэл хуваарилалт | Шударга, ил тод, нээлттэй | Төсвийн нөлөө, хяналт | Урт хугацаанд тогтвортой | Байгаль орчин, ногоон хөгжил |
|---|---|---|---|---|---|---|
| Олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, үйлчилгээ үзүүлэх | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төсөв санхүүгийн удирдлага, хяналт зохицуулалт | Эрх үүргийг тодорхойлох, Эрсдэлийг оновчтой хуваарилах, гүйцэтгэлд үндэслэсэн санхүүжилт | Сонгон шалгаруулалтыг эрх тэгш, өрсөлдөөнд суурилсан зохион байгуулж, үр дүнг нийтэд мэдээлэх | Төсөвт үзүүлэх эрсдэлийг тооцох, санхүүжилтийн хяналтыг тогтмол хэрэгжүүлэх | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, оролцоог дэмжих эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх | Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлж, ногоон эдийн засгийг дэмжих |

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО

**2022.12.09**
ТХХТтХууль шинэчлэгдэн батлагдсан

**2023.11.15**
ТХХТтХуулийн дагалдах журмууд батлагдсан

**2023.12.31**
ТХХТтХууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн

**2024.08.07**
“ТХХТ-ийн төв” ТӨААТҮГ байгуулагдсан

**2025.06.25**
ЭЗХЯ-ны бүтцэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газар болж шинэчлэгдсэн

**2025.11.14**
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан

**2025.03.04**
Төр, хувийн хэвшлийн түншлэлийн журмуудын нэмэлт, өөрчлөлтийг ЗГ-ын тогтоолоор баталсан

# ХУУЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль **2022.12.09-ний өдөр** батлагдсан бөгөөд **2023.12.31-ний өдрөөс** хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.



# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр — Улаанбаатар хот

### ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:**

"13.4.Аймаг, нийслэл энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан төсвөөс санхүүжүүлэх түншлэлийн төрлөөр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийн эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг, энэ хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлтийг авна."

**2/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:**

"18.4.Энэ хуулийн 5.1.13-т заасан төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийж болно."

**3/20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэг:**

"20.11.Энэ хуулийн 20.4.2-т заасан техник, эдийн засгийн үндэслэлийг төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтээр боловсруулж болох бөгөөд тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн шинжилгээ хийх шийдвэр гарахаас өмнө гурван жилийн дотор тухайн салбарын шинжлэх ухаан, технологийн, эсхүл мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж тодотгосон байна."

**4/43 дугаар зүйлийн 43.8 дахь хэсэг:**

"43.8.Төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийг түншлэлийн төсөлд нэвтрүүлснээс олсон түншлэлийн төслийн орлогын 5 хүртэлх хувийг оюуны өмчийн эрх эзэмшигчийн инноваци, судалгаа хөгжүүлэлттэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулж болно."



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

**2 дугаар зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.15 дахь заалтын "байгаль орчинд ээлтэй" гэсний дараа "; инноваци, шинэ" гэж, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсгийн "зөвшөөрлийг" гэсний өмнө "санал, дүгнэлт," гэж, 21.7 дахь хэсгийн "байгууллагын" гэсний дараа "санал, дүгнэлт гарсан," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:**

"8.1.3.энэ хуулийн 20.4-т заасан төслийн бүрэн шинжилгээг хянаж, санал, дүгнэлт гарган, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;"

**2/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:**

"8.2.Түншлэлийн төслийн санал хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэх бөгөөд холбогдох журмыг түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

**3/9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.5 дахь заалт:**

"9.1.4.түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, энэ хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлт, 14.1.2, 14.1.3-т заасан түншлэлийн төрөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл өгөх, зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.1.5.түншлэлийн гэрээний төсөлтэй танилцаж, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээг хянах, түншлэлийн гэрээ байгуулах болон түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;"

**4/11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалт:**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

"11.2.2.энэ хуулийн 13.2.1, 13.2.2, 13.2.3, 13.2.4, 13.2.5, 13.2.6-д зааснаас бусад салбарт хэрэгжүүлэх 100 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй түншлэлийн төслийн саналаа Түншлэлийн төвд хүргүүлэх;"

**5/12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалт:**

"12.2.2.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл болон хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналыг хүлээн авах, түншлэгч талуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;"

**6/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:**

"13.2.Аймаг, нийслэл дараах салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлж болно:"

**7/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:**

"18.1.Түншлэлийн төсөл нь хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байна:"

**8/25 дугаар зүйл:**

**"25 дугаар зүйл.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах**

25.1.Хувийн хэвшлийн түншлэгчийн шалгуур үзүүлэлтийг дараах баримт бичигт тусган сонгон шалгаруулалтын дагуу шалгаруулна:

25.1.1.түншлэлийн төслийн танилцуулга, төслийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, нийтийн зориулалттай дэд бүтцийн төслийн хувьд техник, эдийн засгийн үндэслэл, жишиг маягт, төсөл хэрэгжүүлэх төрийн түншлэгчийн талаарх мэдээлэл, тайлбар;

25.1.2.хувийн хэвшлийн түншлэгчийн үзүүлэх үйлчилгээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл;

25.1.3.төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийн санхүү, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага;

25.1.4.түншлэлийн гэрээний нөхцөл;
25.1.5.оролцогчид тавигдах шаардлага;



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

25.1.6.сонгон шалгаруулах арга хэлбэр, аргачлал, оролцогчид өгөх заавар, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

25.1.7.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

25.2.Энэ хуулийн 24.1-д заасан ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг холбогдох журмын дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

25.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

25.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн төслийн саналыг үнэлж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлэн дараалуулах байдлаар сонгон шалгаруулж, шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлнэ.

25.5.Ажлын хэсэг шаардлага хангасан оролцогчтой дарааллын дагуу гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг шалгаруулна.

25.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээлж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт авах хүсэлтийг хүргүүлнэ.

25.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авч, түншлэлийн гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт гаргаж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор хүргүүлнэ.

25.8.Түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 26.5-д заасан шийдвэрийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулж, олон нийтэд мэдээлнэ.

25.9.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно."

**9/26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:**

"26.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтээ санхүү,



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

25.1.6.сонгон шалгаруулах арга хэлбэр, аргачлал, оролцогчид өгөх заавар, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

25.1.7.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

25.2.Энэ хуулийн 24.1-д заасан ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг холбогдох журмын дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

25.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

25.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн төслийн саналыг үнэлж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлэн дараалуулах байдлаар сонгон шалгаруулж, шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлнэ.

25.5.Ажлын хэсэг шаардлага хангасан оролцогчтой дарааллын дагуу гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг шалгаруулна.

25.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээлж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт авах хүсэлтийг хүргүүлнэ.

25.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авч, түншлэлийн гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт гаргаж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор хүргүүлнэ.

25.8.Түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 26.5-д заасан шийдвэрийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулж, олон нийтэд мэдээлнэ.

25.9.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно."

9/26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:

"26.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтээ санхүү,

2389

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2025 он №46/1391/

төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулан түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна."

**4 дүгээр зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтын "зөвшөөрөл олгох" гэснийг "санал, дүгнэлт гаргах" гэж, 8 дугаар зүйлийн 8.1.16 дахь заалтын "Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах" гэснийг "санал, дүгнэлт авах" гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн "Түншлэлийн болон" гэснийг "Түншлэлийн төв болон" гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн "салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад" гэснийг "Түншлэлийн төвд" гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн "25.6.7-д" гэснийг "25.5-д" гэж, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн "түншлэлийн гэрээ байгуулах эсэх зөвшөөрлийг ажлын 10 өдөрт багтаан олгоно." гэснийг "санал, дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан ирүүлнэ." гэж, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн "зөвшөөрөлд үндэслэн" гэснийг "санал, дүгнэлтийг авч," гэж, мөн зүйлийн 39.3 дахь хэсгийн "зөвшөөрөл" гэснийг "санал, дүгнэлт" гэж, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн "25.2.6, 25.6.8-д" гэснийг "25.4-т" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.24 дэх заалтын "урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан" гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын "төслийн саналыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн авах," гэснийг, 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.б дэх дэд заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь заалтын "урьдчилсан болон нарийвчилсан" гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн "тусгай" гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.5.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын "нарийвчилсан" гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА** **Ж.БАТ-ЭРДЭНЭ**

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

## I Бүх аймагт түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжийг нээсэн

- Одоогийн хуулиар түншлэлээр төсөл хэрэгжүүлэх хуулийн шаардлагыг хангаж буй **9 аймаг** байгаа бол хуулийн **нэмэлт, өөрчлөлтөөр 21 аймагт** түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломж бүрдсэн.
- Аймаг, нийслэл, хувийн хэвшлээс түншлэлийн төслийн саналаа **түншлэлийн төвд** шууд гаргаж урьдчилсан үнэлгээг хийлгэдэг болсон.

**НИЙСЛЭЛ + 21 АЙМАГ**

## II Түншлэлийн төсөлд тавигдах шаардлагуудыг тодорхой болгосон

- Нийтийн зориулалттай **Төрийн үйлчилгээний төсөлд** төслийн онцлогоос хамаарч ТЭЗҮ шаардахгүй.
- Түншлэлийн төсөлд тавигдах **нийтлэг болон тусгай шаардлагыг** тодорхой болгосон.
- Түншлэлийн төслийн санал гаргагч **өөрийн хөрөнгөөр ТЭЗҮ** хийснийг хүлээн зөвшөөрнө.

**ҮЙЛЧИЛГЭЭ = ТЭЗҮ (-)**

## III Оюуны өмчийг эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлсэн

- Төрийн болон орон нутгийн өмчид хамаарах **оюуны өмчийг** түншлэлийн төсөлд нэвтрүүлж, орлого олох боломжийг нээсэн.
- Тус орлогын **5 хүртэлх хувийг** оюуны өмчийн эрх эзэмшигчийн инноваци, судалгаа хөгжүүлэлтэд зарцуулж болно.
- Төслийн санал хүлээн авахаас, сонгон шалгаруулж шийдвэр гаргах хүртэл бүх процессыг **цахим системээр гүйцэтгэнэ.**

**ОЮУНЫ ӨМЧ – ОРЛОГО**

## IV Сонгон шалгаруулалтыг нэг үе шаттай болгосон

- Урьдчилсан болон уралдаанд шалгаруулалтыг нэгтгэж **нэг үе шаттай болгож хугацааг хэмнэсэн.**
- Оролцогчид тавих шалгуур үзүүлэлтийг **давхцалгүй, тодорхой, ойлгомжтой болгосон.**
- Олон нийт, оролцогчид **мэдээлэл авах** хугацааг тодорхой болгосон.
- Шаардлаггүй зарим **шат дамжлагыг бууруулах,** хугацааг тодорхой болгосон.

**ШАЛГАРУУЛАЛТ – НЭГ ҮЕ ШАТ**

# АЙМАГ, НИЙСЛЭЛ ТҮНШЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ



**НИЙСЛЭЛ, БҮХ АЙМАГТ ТҮНШЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛНЭ:**

1. Нийслэл
2. 21 аймаг

**АЙМАГ, НИЙСЛЭЛ ТҮНШЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ:**

- ✓ Аймаг, нийслэлийн засаг дарга нь түншлэлээр хэрэгжүүлэх төслийг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэх;
- ✓ ИТХ төслийн жагсаалт, түншлэлийн гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгох;

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ САЛБАР:**

1. Эрчим хүч, дулаан хангамж
2. Хог хаягдлын менежмент
3. Гадаргын ус, саарал усны барилга байгууламж, менежмент
4. Цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж
5. Хурдны зам, багтаамж ихтэй нийтийн тээвэр, тээвэр логистикийн төв
6. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах барилга байгууламж

+

**100 тэрбум төгрөг болон түүнээс доош өртөгтэй төсөл**

# ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ПРОЦЕСС

| ҮЕ ШАТ | Шийдвэрлэх | Гүйцэтгэх | Хийгдэх ажил | |
|---|---|---|---|---|
| Төслийг тодорхойлох | Салбар яам (Орон нутаг, Хувийн хэвшил) | Түншлэлийн төв, Салбар яам | Урьдчилсан үнэлгээ | Бүрэн шинжилгээ хийх журам |
| ТХХТ ТОХИРОМЖТОЙ → БУЦААЛТ | | | | |
| Хөгжлийн баримт бичигт тусгах | УИХ | ЭЗХЯ, Салбар яам | Хөгжлийн жилийн төлөвлөгөө, УХОХ | |
| Бүрэн шинжилгээ хийх | ЭЗХЯ, Сангийн яам | Төслийн баг, Түншлэлийн төв | ТЭЗҮ /төслөөс хамаарна/, Мөнгөний үнэ цэнэ Эрсдэл, Төсвийн нөлөөлөл | Эрсдэл тооцоолох аргачлал |
| ЗГ → ТХХТ ХЭРЭГЖҮҮЛЭХ → БУЦААЛТ | | | | |
| Сонгон шалгаруулалт | ЭЗХЯ, Сангийн яам | Ажлын хэсэг | Сонгон шалгаруулалт хийх | Сонгон шалгаруулах журам |
| ЗГ → ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ → ДАХИХ | | | | |
| Гэрээ байгуулах | ЭЗХЯ | ЭЗХЯ, Салбар яам, Орон нутаг | Түншлэлийн гэрээ | Гэрээ байгуулах журам |
| Хэрэгжүүлэх | | ЭЗХЯ, Салбар яам, Орон нутаг | Хяналт, тайлагналт, санхүүжилт | Хэрэгжилт, тайлагналт, санхүүжилтийн журам |
| Төрд шилжүүлэх | ЭЗХЯ | Хамтарсан ажлын хэсэг | Гэрээний дагуу | |

# ХУВИЙН ХЭВШИЛ ТӨСӨЛ САНААЧЛАХ



ДАРААХ САЛБАРУУДАД **ХУВИЙН ХЭВШИЛ** АШИГТАЙ ТӨСЛҮҮДИЙГ САНААЧИЛЖ **ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ**

### Эрчим хүч

- Сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус/
- Дулааны цахилгаан станц

### Дэд бүтэц

- Харилцаа холбоо, мэдээллийн технологи
- Усан хангамж, цэвэрлэх байгууламж

### Төрийн үйлчилгээ

- Боловсрол
- Эрүүл мэнд

### Зам тээвэр

- Авто зам, хурдны зам
- Төмөр зам
- Нисэх буудал

### Байгаль орчин

- Хог хаягдал, дахин боловсруулалт
- Усны төслүүд

### Аялал жуулчлал

- Музей, интерактив контент
- Эко парк
- Жуулчны бааз
- Фестиваль, арга хэмжээний төв

## ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

- **Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт** үзүүлэх
- Газрын хуульд заасны дагуу **газар эзэмших, ашиглах** эрхээр хангах
- Төслийн санхүүжилтийн тодорхой хэсгийг **төсвөөс санхүүжүүлэх**
- Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай **дэд бүтэц, төрийн үйлчилгээгээр** хангах
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг **ашиглах эрх** олгох

## ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА

- Гэрээний гол нөхцөл зөрчигдсөн тохиолдолд төсвөөс санхүүжүүлэх **үүргийн баталгаа**
- Төслийн хүрээнд бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, ашиглах, хэрэглэх **эрэлтийн баталгаа**

# ХУВИЙН ХЭВШЛЭЭС ТӨСӨЛ САНААЧЛАХ ПРОЦЕСС

**Хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналд хуульд заасан шаардлага, нөхцөл, журам нэгэн адил үйлчилнэ.**




Хувийн хэвшил төслийн саналаа Түншлэлийн төвд гаргана. Салбарын яамтай хамтран урьдчилсан үнэлгээ хийнэ.

Төсөл санаачлагч хувийн хэвшил нь бүрэн шинжилгээ хийхтэй холбогдсон зардлыг **өөрийн хөрөнгөөр** санхүүжүүлнэ.

Хувийн хэвшлийн төсөл санаачлагч этгээд сонгон шалгаруулалтын өрсөлдөөнд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил үнэлгээний шалгуурт хамаарах ба үнэлгээнд сонгон шалгаруулалтын журамд заасан **давуу эрхийн оноог** олгоно.

Сонгон шалгаруулалтын хугацаанд тодорхой **санал ирээгүй тохиолдолд** анх санал ирүүлсэн оролцогчтой хэлэлцээ хийх ба гэрээ байгуулах шийдвэрт хүрсэн тохиолдолд энэ хуульд заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулна.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТОГТООЛ



## 2025.08.27 – 60 дугаар тогтоол

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 27 өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл”-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн “барих, ашиглах, шилжүүлэх” гэрээний төрлөөр хэрэгжүүлсүгэй.

2.Төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нарт даалгасугай.

3.“Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл”-ийн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын үүргийн баталгаа гаргах асуудлыг шалгарсан түншлэгчтэй байгуулах гэрээнд тусган, түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтээ танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Н.УЧРАЛ

## 2026.01.07 – 02 дугаар тогтоол

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 07 өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор нийслэлээс санаачилсан "Улаанбаатар (УБ) арена" төслийн саналыг дэмжсүгэй.

2.Энэ тогтоолын 1-д заасан төслийг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн хэрэгжүүлэхийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТОГТООЛ



## 2026.03.04 – 63 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04 өдөр | Дугаар 63 | Улаанбаатар хот

Журам, жишиг баримт бичиг шинэчлэн
батлах, тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 7.2.1, 7.2.2, 7.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.“Журам, жишиг баримт бичиг, гэрээний загвар, аргачлал батлах тухай” Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 404 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам”-д доор дурдсан агуулга бүхий $5.1^1$ дэх хэсэг нэмсүгэй:

“$5.1^1$.Төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийж болно.”

3.Мөн журмын 9.2 дахь хэсгийн “2 дугаар бүлэгт заасан урьдчилсан үнэлгээг хийж,” гэсний дараа “түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд” гэж нэмсүгэй.

4.Мөн журмын 2.1, 2.2, 2.5, 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.1.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана.

2.2.Аймаг, нийслэлийн хэмжээнд түншлэлээр хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11.2.2-т заасан төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана.

2.5.Түншлэлийн төв энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүлээн авна.

“Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг”, мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журам”-ын 3.4, 3.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

## 2026.03.04 – 64 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04 өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан байгуулах, журам батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 405 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих журам"-ын 3.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.6.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан хугацаа, стандарт болон зардлын дагуу түншлэлийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргаж, төлбөрийг гэрээнд заасны дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан аймаг, нийслэлд хэрэгжүүлэх түншлэлийн төслийн хувьд орон нутгийн болон нийслэлийг хөгжүүлэх санд гэрээ байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө тус тус шилжүүлнэ.”

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

## 2026.03.04 – 65 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04 өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Маргаан шийдвэрлэх зөвлөлийг байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай” Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 406 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журам”-ын 4.2 дахь хэсгийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.6, 25.6.8-д заасан” гэснийг “Ажлын хэсгээс сонгон шалгаруулалтад оролцогчид” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТОГТООЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр | Дугаар 210 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.8, 13.2, 13.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хүрээнд "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт, "Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам"-ыг 3 дугаар хавсралт, "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батлсугай.

2.Энэ тогтоолыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан болон Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД — Л.ГАНТӨМӨР

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН 210 ДУГААР ТОГТООЛООР АЙМАГ, НИЙСЛЭЛД ТҮНШЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДАГАЖ МӨРДӨХ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫГ БАТАЛСАН.**

- ✓ "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам",
- ✓ "Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам",
- ✓ "Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам",
- ✓ "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТОГТООЛ

## 2023.12.27 – 474 дугаар тогтоол

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр | Дугаар 474 | Улаанбаатар хот

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам"-ыг хавсралт ёсоор батлсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

## 2023.12.27 – 475 дугаар тогтоол

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр | Дугаар 475 | Улаанбаатар хот

**ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралт ёсоор батлсугай.

2.Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

# ТХХТ-ЭЭР НИЙСЛЭЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ



## 2025.01.27 – 25/01

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР НИЙСЛЭЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ**

НИЙТ
**33**
ТӨСӨЛ

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр — Дугаар 25/01 — Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төр хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан жагсаалтад туссан түншлэлийн төслүүдийн бүрэн шинжилгээг хийж, холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА А.БАЯР

## 2025.09.19 – 25/109

**25/01 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

ХАВСРАЛТЫН 11-Т ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН

**5** ▲ Төсөл

НИЙТ
**38**
ТӨСӨЛ

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 19 өдөр — Дугаар 25/109 — Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Төр хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай" 25/01 дүгээр тогтоолын хавсралтын 11-т өөрчлөлт оруулж, мөн төслийн жагсаалтын нэмэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2.Төслийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан баталсан төслүүдийн бүрэн шинжилгээг хийж, холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжилтийг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА А.БАЯР

## 2025.12.05 – 25/137

**25/01 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**3** ▲ Төсөл

НИЙТ
**41**
ТӨСӨЛ

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 05 өдөр — Дугаар 25/134 — Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/01 дүгээр тогтоолоор баталсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт"-д оруулах нэмэлтийг хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА А.БАЯР

# ТХХТ-ЭЭР АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

## 2025.07.25 – 06/09

**ДОРНОГОВЬ АЙМАГ**

НИЙТ
**2**
ТӨСӨЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 25 өдөр    Дугаар 06/09    Сайншанд сум

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр
хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15, 35 дугаар зүйлийн 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Засгийн газрын "Говийн бүсийн хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 233 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд суманд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалт, газрын хэмжээ, байршлыг хавсралтаар батлсугай.

2.Батлагдсан төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, "Их говийн хөгжлийн гарц" ОНӨААТҮГ-т газар эзэмших эрхийг олгож, төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хорооны ахлагч (Ч.Түвшинтөр), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА    Н.АЛДАРБАЯР

442250067

## 2026.03.26 – 10

**УВС АЙМАГ**

НИЙТ
**7**
ТӨСӨЛ



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 26 өдөр    Дугаар 10    Улаангом

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай
хуулийн хүрээнд хэрэгжүүлэх, төсөл арга
хэмжээний жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.18, Төр,хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд Увс аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Засаг дарга (Э.Насанбат)-д даалгасугай.

